

БАТЛАВ:

БОУАӨЯ-ны Хүрээлэн буй орчин,

байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга:

Г. Энхмөнх

“Тэфис майнинг” ХХК-ийн

Гүйцэтгэх захирал:

Д. Чанцал

**ХОВД АЙМАГ, ДАРВИ СУМЫН МӨРӨН БАГТ
БАЙРЛАХ “ЗҮҮН ХӨШӨӨТ” НҮҮРСНИЙ
УУРХАЙН ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН
2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР:МV-018291, МV-018293/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР:2807459/

ХЯНАСАН:

БОУАӨЯ-ны ХБОБНУГ-ын

мэргэжилтэн

Солонго

Боловсруулсан:

ХАБЭАБО-ны менежер

М. Дуламжав

2026 ОН

ГАРЧИГ

1. Товч танилцуулга.....	4
1.1 Төслийн байршил	4
1.2 Гаалийн хяналтын бүсийн талбайн дотоод зохион байгуулалт.....	7
1.3 Гаалийн хяналтын бүсэд ажиллах техник, тоног төхөөрөмжүүд:.....	8
2. Төслийн талбай орчмын байгаль орчны төлөв байдал	10
2.1 Бүс нутгийн уур амьсгалтын бүсчлэл	10
2.2 Гадаргын ус.....	12
2.3 Газрын доорх ус.....	14
2.4 Хөрсний хэв шинж	15
2.5 Ургамлан нөмрөгийн онцлог	16
2.6 Амьтны аймгийн зүйлийн бүрдэл, тоо толгой, тархалт	16
3. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ.....	18
3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах.....	18
3.2. Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	19
3.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах.....	19
3.4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах.....	20
3.5. Ажилчдын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах.....	21
3.6. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	21
4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт.....	23
4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	24
4.2 Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөө	26
4.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө... 26	
4.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	26
4.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	26
4.6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	27
4.7 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	29
4.8 Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө.....	30
4.9 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	31

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Солбилцлын цэг	5
Хүснэгт 2. Гаалийн хяналтын бүсийн барилга, байгууламж	8
Хүснэгт 3. Төсөл хэрэгжих үеийн голлох нөлөөллийн хамрах хүрээ, түүний эрчим	18
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	24
Хүснэгт 5. Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөө	26
Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	27
Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	29
Хүснэгт 8. Удирдлаг, зохион байгуулалтын төлөвлөгөө	30
Хүснэгт 9. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө	31
Хүснэгт 10. 2026 оны гаалийн хяналтын бүсийн БОМТ-ний нийт зардал	32

ЗУРГИЙН ЖАГСААЛТ


Зураг 1. Төслийн талбайн байршил	4
Зураг 2. Гаалийн хяналтын бүсийн загвар	5
Зураг 3. Гаалийн хяналтын бүсийн одоогийн зураг	6
Зураг 4. Гаалийн хяналтын талбайн нүүрсний овоолго	7
Зураг 5. Камержуулалт	8
Зураг 6. Гаалийн хяналтын талбайн схем зураг	9

1. Товч танилцуулга

№	Төслийн нэр	Гаалийн хяналтын талбай
1	Төсөл хэрэгжүүлэгч	“Тефис Майнинг” ХХК
		УБГ дугаар: 9011423138
		Регистрийн дугаар: 2807459
2	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг, утас	Улаанбаатар хот, Хан уул дүүрэг, 2-р хороо, “Монгол савхи” компанийн байр 6-602 тоот Утас: 7720535 99119567
3	Төслийн талбайн хэмжээ	100000.0 квадрат метр
4	Төслийн байршил	Ховд аймгийн Дарви сумын Мөрөн багийн нутагт байрлалтай Хөшөөтийн нүүрсний ордын зүүн зах хэсэг бөгөөд Дарви сумын төвөөс баруун урагш 45км, Цэцэг сумын төвөөс зүүн хойш 26 км зайтай байрлана.



1.1 Төслийн байршил

Зүүн Хөшөөтийн нүүрсний орд нь Ховд аймгийн Дарви сумын нутагт Улаанбаатар хотоос баруун тийш 1272км, Ховд хотоос зүүн урагш 210 км-т, Дарви сумаас баруун урагш 60 км, Цэцэг сумаас хойш 30 км-т, Алтайн нурууны үргэлжлэл дээр оршино.




Зураг 1. Төслийн талбайн байршил

Д/д	Уртраг	Өргөрөг
1	93.31809	46.78313
2	93.31876	46.78457
3	93.32076	46.78555
4	93.32365	46.78491
5	93.32238	46.78225



Зураг 2. Гаалийн хяналтын бүсийн загвар



Зураг 3. Гаалийн хяналтын бүсийн одоогийн зураг

“Тетфис Майнинг” ХХК нь Ховд аймгийн Дарви суманд орших “Зүүн Хөшөөт”-ийн чулуун нүүрсний ил уурхайн төслийн үйл ажиллагааг 2018 оны гуравдугаар улирлаас эхлүүлсэн. Хөшөөтийн нүүрсний ордын зүүн хэсэгт бодитой (В), боломжит (С) зэргээр 44,645,082 тн нөөц тогтоогдсон бөгөөд ордын уул геологийн нөхцөл, нүүрсний давхаргын зузаан, унал, сунал, хөрсний зузаан, физик механик шинж чанар зэрэгт үндэслэн одоогийн ашиглалтын системээр буюу ил аргаар, экскаватор- автосамосвалын хослол бүхий авто тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглахаар ТЭЗҮ (тодотгол) боловсруулагдсан. Ил уурхайн хүчин чадал нь техникийн даалгавар болон зах зээлийн эрэлт, нүүрсний тээвэрлэлт хийх зсaмын нөхцөл байдалд үндэслэн 1.35 сая.тн/жил коксжих нүүрс байхаар тусгасан.

Техник эдийн засгийн үндэслэлд заасны дагуу ордын олборлолтын үйл ажиллагааг явуулж олборлосон нүүрсийг экспортлох эцсийн бүтээгдэхүүнийг Монгол улсын засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 05 өдрийг 362 дугаар тогтоолоор хил нөхцөлөөр борлуулах болсоныг үндэслэн Монгол улсын хилээр экспортлоход гаалийн байгууллагын хяналтан дор ачиж, гаалийн бүрдүүлэлт хийх ёстой тул тухайн байгууллага нь гаалийн хяналтын бүсийг байгуулах шаардлага үүссэн байна.

1.2 Гаалийн хяналтын бүсийн талбайн дотоод зохион байгуулалт

Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/339 тоот тушаалд заасан гаалийн хяналтын бүсэд тавигдах нөхцөл шаардлагын дагуу “Гаалийн хяналтын бүс”-эд орох, гарах хаалганаас бусад газраар бараа, тээврийн хэрэгсэл, бие хүн нэвтрэх боломжийг хаасан 10 га газарт хашаажуулж, 8 га газарт нүүрсний ул дэвсэж овоолго үүсгэх талбай бэлдсэн.



Зураг 4.Гаалийн хяналтын талбайн нүүрсний овоолго

Гаалийн байгууллагатай мэдээллийн сүлжээнд холбогдон гаалийн хяналтын бүсэд гаалийн хяналт тавихад шаардагдах техник, тоног төхөөрөмж суурилуулсан. Гаалийн хяналтын бүсэд нийт 18 ширхэг хяналтын камер байрлуулж, талбайн гэрэлтүүлэг лед нийт 4 ширхэг гэрэл байрлуулсан)



Зураг 5. Камержуулалт

Хүснэгт 2. Гаалийн хяналтын бүсийн барилга, байгууламж

№	Байгууламжын зориулалт	Тоо	Хэмжээ /метр/	Тайлбар
1	Гаалийн байцаагчийн байр	1	6x6	
2	Гаалийн мэдүүлэгчийн байр	1	3x4	
3	Автопүүний ажлын байр	1	3x3	Автопүүний байр
4	Автопүүний ажлын байр	2	3x4	Автопүүний байр
5	Нийт автопүүний байр	2		
6	Хучилтын тавцан /нэг зэрэг 3 машин орох/	1	15x18	15*18м хэмжээтэй,
7	Харуулын хамгаалатын байр	1	3x3	Орох гарах хаалган дээр байна
8	Хяналтын бүсийн хашаа	1.200	1.5x1200	1.5 метрийн өндөртэй хашаа

1.3 Гаалийн хяналтын бүсэд ажиллах техник, тоног төхөөрөмжүүд:


Гаалийн хяналтын талбайн ачилтанд нийт 4 авто ачигч, нэмэлт хасалтанд нэг авто ачигч ажиллана. LiuGonG 863 маркийн, 6м³ шанаганы багтаамжтай дугуйт ачигч 3 ширхэг, Гаалийн хяналтын бүсийн усалгааг 40 тонны багтаамжтай нэг усны машин, түлшний машин /запрушиг/, хогны машин тус тус ажиллана.



LiuGong -LG863



LiuGong- 870H



Зураг 6. Гаалийн хяналтын талбайн схем зураг

2. Төслийн талбай орчмын байгаль орчны төлөв байдал

Газрын гадаргын хувьд ерөнхийдөө уул нуруутай, ухаа гүвээг талын байрлалтай. Талбай орчмын гадаргуугийн өндөр нь 908-1086 м өндрийн түвшинд хэлбэлзэнэ.

2.1 Бүс нутгийн уур амьсгалтын бүсчлэл

Чийг хангамжийн үзүүлэлт далайн түвшнээс 1500м-ээс нам газартаа 0.1-0.2 буюу нэн хуурай дулаан бүсэд тус тус хамаарна. Төслийн бүс нутаг бол манай орны хамгийн салхи ихтэй газар нутгийн нэг бөгөөд жилийн дундаж салхины хурд 1-2 м/с, хаврын саруудын салхины дундаж хурд 3.0-3.4м/с. Төслийн бүс нутагт жилийн дундаж байдлаар баруун-баруун хойд, хойд зүгийн салхи зонхилох боловч орон нутгийн салхи тод илэрнэ.

Хөшөөт орчмын газар нь өндөр уулын бүсдээ хамаарах ба өвлийн улиралд бусад нутгаас дулаан, зуны улиралд сэрүүн байдаг онцлогтой. Энэ нь агаарын температур зуны улиралд өндрөөсөө хүйтэрч, өвлийн улиралд дулаардаг зүй тогтолтой холбоотой бөгөөд өндөр уулын бүсийн нутагт өвөл зуны температурын хэлбэлзэл бусад нутгаас харьцангуй бага, байнга сэрүүн байна. Зуны улиралд агаарын температур өндөрсөх тутам сэрүүсдэг.

Агаарын температур: Агаарын температур нь зуны улиралд өндрөөсөө хүйтэрч, өвлийн улиралд дулаардаг зүй тогтолтой холбоотой бөгөөд өндөр уулын бүсийн нутагт өвөл зуны температурын хэлбэлзэл бусад нутгаас харьцангуй бага, байнга сэрүүн байна. Зуны улиралд агаарын температур өндөрсөх тутам сэрүүсдэг. Агаарын дундаж температурын утгаас үзэхэд хүйтний улиралд $-0,6-(-28,2^{\circ}\text{C})$ хэм хүртэл хүйтэрч байсан бол дулааны улиралд $2,9-24,6^{\circ}\text{C}$ хэм хүртэл дулаарсан байна. 2016-2023 оны хамгийн их хүйтэрч байсан жил нь 2018 оны 1-р сард $-28,2^{\circ}\text{C}$ хэм хүрч байсан бол хамгийн их дулаарч байсан сар нь 2019 оны 7-р сард $24,6^{\circ}\text{C}$ хэм хүрсэн байна.

Агаарын үнэмлэхүй их, бага температур: Ховд станцын 2016-2023 оны агаарын их температурын утгаас үзэхэд хүйтний улирлын температур $-0,2-9,5^{\circ}\text{C}$ хэм хүртэл хүйтэрч байсан бол дулааны улирлын температур $1,2-34,9^{\circ}\text{C}$ хэм хүртэл дулаарсан байна. Агаарын үнэмлэхүйн их температурын хэмжилтийн мэдээнээс харахад 2017 оны 7-р сард $34,9^{\circ}\text{C}$ хэм хүрсэн бол хүйтний улирлын хамгийн их температур нь $-9,^{\circ}\text{C}$ хэм хүрсэн байна.

Ховд аймгийн Ховд станцын 2016-2023 оны агаарын үнэмлэхүйн бага температурын утгаас үзэхэд хүйтний улиралд $-0,3-(-40^{\circ}\text{C})$ хэм хүйтэрч байсан бол дулааны улиралд $1,1-11,3$ хэм хүртэл дулаарч байсан байна. Хамгийн их хүйтэрч байсан жил нь 2018 оны 1-р сард 40°C хэм хүрч байсан бол хамгийн их дулаарч байсан сар нь 2016 оны 7-р сард $11,3^{\circ}\text{C}$ хэм хүрсэн байна.

Хөрсний температур: Хөрсний гадарга дээр зундаа 57-61⁰С хүртэл халж, өвөлдөө -40...48⁰С хүртэл хүйтэрдэг. Газрын гүнд температурын хувиарлалт нь тодорхой зүй тогтолтой. Зуны улиралд гүн ихсэхээр температур буурч, өвлийн улиралд гүн рүүгээ дулаарч, хавар, намар шилжилтийн байдалтай, тухайлбал IV, X сард дунд гүндээ (0.8,1.2 м) дулаан, хоёр тийшээ сэрүүсэх явцтай байдаг.

Агаарын даралт, салхины горим: Ховд станцын агаарын даралт нь 852-869 гПа-ийн хооронд хэлбэлзэж байна. Бусад онуудтай харьцуулахад агаарын даралт хамгийн өндөр байгаа сар нь 2016 оны 2-р сард 869гПа байгаа бол хамгийн бага агаарын даралт нь 2012 оны 7-р сард 852 гПа байна.

Салхины горим: Төслийн бүс нутаг бол манай орны нэлээд салхидуу газар нутгийн нэг бөгөөд жилийн дундаж салхины хурд 1-2 м/с, хаврын саруудын салхины дундаж хурд 3.0-3.4 м/с байдаг. Салхины хурдны жилийн явцад хавар, намрын улиралд 2 удаагийн максимум утга, өвөл, зуны улиралд 2 удаа минимум утга ажиглагдах бөгөөд хаврынх нь үндсэн их утга байх агаад чухам агаар, хөрс хамгийн хуурай үе, салхины хүч хамгийн их үе хоёр давхцахаас болж жилд тохиолддог хүчтэй салхитай болон шороон шуургатай өдрийн тооны ихэнх хувь нь зөвхөн хаврын 3 сард тохиолдоно.

Ховд станцын 2016-2023 оны салхины үнэмлэхүй хурдын хэмжилтийн утгыг харахад 3-34 м/с-ийн хооронд салхины хурд хэлбэлзэж байна. Хүйтний улиралд 3-25 м/с хүртэл салхилсан бол дулааны улиралд 14-34м/с хурдтай салхи салхилсан байна. Салхины хурд хамгийн өндөр байсан сар нь 2017 оны 9-р сард 34 м/с хурдтай салхи салхилсан байна.

Агаарын чийгшил, хур тунадас: Энэ бүс нутагт жилдээ тал хөндий газартаа 75- 100 мм, өндөр уулсын райондоо 200-225 мм орчим хур тунадас орох бөгөөд хур тунадасны 90% орчим нь жилийн дулаан улирал (IV-IX сард)-д ордог. Ховд станцын 2016-2023 оны хур тунадас хамгийн их орсон сар нь 2021 оны 6-р сард 95.2 мм хур тунадас орсон байна. Өвлийн улиралд хамгийн их хур тунадас орсон сар нь 2016 оны 1 дүгээр сард хамгийн их буюу 6.6мм хур тунадас орсон байна.

2.2 Гадаргын ус

Ховд аймгийн Дарви сум нь Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газарт хамрагдана. Тал бүрээсээ говь цөл нутгаар хүрээлэгдсэн Алтай нурууны нэг хэсэг болох Сутайн баруун хойт салбар уулсаар чийгшил бага болохоор гол мөрний сүлжээ ерөнхийдээ сийрэг. Нүүрсний ордод хамаарагдах хэрчигдэл ихтэй уулархаг хэсгүүдээр хуурай сайрууд олонтой. Харин төслийн талбайн зүүн хойт талаар уул нуруудын хоорондуур Хөшөөтийн гол зүүн урьдаас баруун хойш чиглэн урсана.

Төслийн талбай орших газар нутаг нь Сутай хайрханы баруун хойд салбар уулсын шувтарга орчмын уулархаг хэсэг тул, хэдийгээр гол мөрний сүлжээ багатай ч газрын гадаргын хэрчигдэл ихтэй, янз бүрийн хэлбэр хэмжээ бүхий хуурай сайр жалга олонтой нутаг юм.

Хур борооны үед эдгээр сайр, жалгуудаар гадаргын түр зуурын урсац богино хугацаанд үүсэх ба хэмжээ болон эрчимшлээсээ хамаарч хол ойр янз бүрийн зайд урсахын зэрэгцээ (Хөшөөтийн гол талын уулын ар хажуугийн сайруудаас бусад нь) хөндий, хотгорын сэвсгэр хурдсанд шурган нэвчих замаар замхран алга болох ерөнхий зүй тогтолтой.

Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газар: Төв Азийн гадагш урсацгүй ай савд хамаарах Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газар манай орны баруун нутагт орших мөнх цас, мөсөн оргил бүхий өндөр уулс, гүн өргөн хавцал хөндий, ой, ойт хээр, тал хээр, говь цөлийн бүс, олон арван гол горхи, нуур, ус намгархаг газруудаас цогцлон бүрдсэн нутаг юм. Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газар нь физик газарзүйн мужлалаар Алтайн уулархаг их мужийн, Монгол Алтайн салбар уулсын мужийн, Алтайн баруун хэсгийн тойрог, Говийн их мужийн, Алтайн ар говийн мужийн, Их нууруудын хотгорын тойрогт тус тус багтана. Энэ сав газарт хотгор, гүдгэрийн хувьд өндөр уулын үндсэн хэв шинж зонхилно.

Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газар нь нийт 43024 км² газар нутгийг хамарч Шарга, Хүйсийн говь, Цэцэг нуурын гадаргын ус хурах талбай, газрын доорх усны нөөц бүрдүүлэх тэжээгдлийн муж, тархалтын талбайн орон зайн ус хагалбараар тус тус хүрээлэгдсэн 2 аймгийн 18 сумын тодорхой нэгж талбайг хамардаг. Усны нөөцийн хувьд ерөнхийдөө жижиг гол горхи, булаг шанд, нуур тойром, болон газрын доорх ус гол нөөцийг бүрдүүлдэг гэж хэлж болно. Газрын доорх усны нөхөгдөх нөөц нь Цэцэг нуурын эргэн тойронд болон Боорж голын адаг, Шаргын цагаан нуурын хөндий, Хүйсийн говь зэрэг нам

доор газар хуримтлагддаг байна. Тус сав газар дахь газрын доорх усны нийт 354 сая шоо метр нөхөн сэргээгддэг. Нөөц байгаа тооцоо гарсны дотор уг нөөцийн зонхилох хэсэг нь бага буюу нэг ам км талбайд 5-10 мм/ жил нөхөн сэргээгддэг нөөцтэй болон тун бага буюу нэг ам км талбайд 0-5 мм/жил нөхөн сэргээгддэг нөөцтэй талбайд хамрагддаг.

Хөшөөт гол: Төслийн талбай орчимдоо хамгийн том нь болохын дээр ойр орчмын бүс нутагтаа томоохонд тооцогдох голуудын нэг нь Хөшөөтийн гол бөгөөд Сутай хайрхан (4200 м) уулын ар, Бага Богд уул (4013 м)-ын зүүн хойд хажуугаас эх авч, талбайн зүүн хойгуур, зүүн урдаас баруун хойш чиглэлтэй урсаж өнгөрөх ба 59 км урсаад Цагаан нуурт цутгана. Голын ус хураах талбай 351 км² бөгөөд голын сүлжээний нягт 0.29 км/км² болно. Хөшөөтийн голын гулдирал (талбайн зүүн хойд хэсэг)-ын өргөн 250-500 м хүрэх ба энэ хэсэг нь гол уулнаас гарч, хөндий нь өргөсөн тавиурах хэсэгт хамаарах тул үертэй үед олон салаа үүсгэн урсана. Томовтор чулуу бүхий хайр чулуун хурдастай.

Уурхайн талбай, түүний ойр хавийн гол горхи, хуурай сайрууд: Уулархаг нутаг учир жижиг сайр, салаа садарга нилээд ихтэй, газар нутгийн үнэмлэхүй өндөр 2300-2560 м, харьцах өндөр 100-400 м орчимд байна. Хөндий, сайрууд нь газар зүйн ерөнхий тогтцыг даган, зүүн урдаас баруун хойш чиглэлтэй байх ба үндсэндээ 2 томовтор хөндий, тэдгээрийн баруун болон зүүн салаа болох тус бүр нэг нэг сайр, нийт 3 томоохон амтай болно.

Хясаалын амны сайр. Эдгээрээс хамгийн том буюу урт хөндий нь Хясаалын ам (энэ ам нь эхэндээ бус харин дундаас доош хэсэгтээ 2 горхитой) бөгөөд дээрээ нэг салаатай, мөн доод хэсэгт баруун гараас цутгах (Тамингийн хөтлийн урдуур, зүүн тийш чиглэлтэй) 260 м- ийн урттэй нэг жалгатай.

Хясаалын ам нь зүүн урдаас баруун хойш чиглэлтэй, 4-5 км урт үргэлжилсэн ба төсөлд хамрагдах талбай дахь хамгийн том бөгөөд урт хөндий боловч үерийн ус урсах голдиролд сайр, жалгын хөгжилт сайн явагдаагүй, эргийн эвдрэл бага, нийт уртын дагууд өвс ургамал, хайрга чулуу, элсээр бүрхэгдсэн гулдирал зонхилно. Тус амны дундаас доош хэсэгт 2 горхи тааралдах ба дээд горхийг нь “Дунд булаг”, доод талын горхийг нь “Хясаалын ус” хэмээн нэрийднэ. Үүний эхнийх нь болох, уг амны 2 хажуу бэлийн уулс бие биедээ тулж, хөндий нарийссан хэсэгт хөрсний ус (гэрийн буурийн чинээ буюу 4x5 м² орчим хэмжээтэй газраас)ил гарч, эхний горхи тэндээс эх авч урсах ба нутгийнхан “Дунд булаг”(460 47’ 37.8”, 930 20’ 45.8”, Н=2144 м) хэмээн нэрлэнэ. Энэ нь доод булаг болох “Хясаалын ус”-ыг бодвол ундарга бага (0.5 л/с), 80-100 м хиртэй урсаад хөрсөнд дахин шургана.

Баруун сайр: Талбайд уулархаг газар хамрагдах тул томоохон хөндий маш бага. Энд уулсын хоорондын нарийхан амуудыг дагасан багаахан талбайг хамруулан үздэг. Энэ талбай дахь “Хар хонд”-ын баруун өмнүүр баруун ба зүүн гараас нийлэх “сайр”-ууд нь харьцангуй богиновтор (270-800 м урттай) хэдий ч сайр жалгын хөгжилт нь эдгээр үндсэн 2 том сайраа бодвол түлхүү явагдсан нь тодхон харагдана. Үүний шалтгаан нь, харьцангуй зөөлөн, хар саарал, хар хүрэн хөрс бүхий газарт тохиосон, газрын гадаргын унал ихтэй зэрэгтэй шууд холбоотой). Энэ 2 сайрын гүн 1.3-1.5 м, өргөн 0.8-1.5 м, хэвгий 0.03 (460 47’30.7”, 93019’39.5”, Н=2081 м). Сул, бор саарал хөрстэй, гулдирал нь бага зэргийн чулуурхаг, элс шороон хурдастай бөгөөд бүтцийг тоймловол, 5-10 см чулуу 10%, 1-5 см чулуу 15% ба үлдэх хэсэг нь элс, шороо болно.

2.3 Газрын доорх ус

Хөшөөтийн голын сав газар нь Монгол орны гидрогеологийн мужлалаар Баруун системийн Хүйсийн говь-Цэцэг нуурын газарт тус тус хамаарна Хөшөөтийн уурхай, Хөшөөтийн гол энэ 2 талбай нь венд-кембрийн цагт үед далай дотор нуурын террейн, силурын цаг үед Ховдын террейн тус тус үүсгэж, атриажилтын явцад атриат мужид хувирсан байна. Хожим девон, пермийн цаг үед эх газрын рифтүүд, мезо-кайнозойн эх газрын уулс хоорондын хотгорууд зэрэг давхацмал структурууд бүхий эх газрын царцдаст муж болж хэлбэршжээ. Бараг баруунаас зүүн тийш чиглэсэн хагарлаар хянагдсан синклиналь, антиклилань атирааны тэнхлэгийн дагуу нүүрсний давхграас нь байрлалтай байдаг.

Төслийн талбайн ихэнх хэсэгт тархсан дээд пермийн настай “Хөшөөт” формацийн нүүрсний ордын геологийн тогтоцын хувьд хэдийгээр үндсэн олборлох нүүрсний үеүд нь тогтвортой боловч хагарал, атириажилтанд эрчимтэй өртсөн, нийлмэл тогтоцтой, огцом ба хөнтрүү уналтай, олон тооны чулуулгийн үеүдтэй чулуулгаас бүрдэх ба мөн дөрөвдөгчийн сэвсгэр хурдас голын хөндийн болон уулын бэл хормойн хэсэгт тархсан.

Хөшөөтийн орд нь урдаасаа хойшоо чиглэсэн антиклиналь тогтоцтой бөгөөд газрын доорх усны урсац нь давхаргын хазайлтыг дагаж, зүүн урдаас баруун хойш чиглэлтэй. Газрын доорх ус нь орших гүн, ус агуулах нөхцлөөс хамаараад урсацын өөр шинж чанартай.

Гидравликийн онцлогоороо судалгааны талбайд тархсан голоцен, плейстоцены настай сэвсгэр хурдасны нүх сүвийн болон уулархаг мужаар тархсан дээд пермийн настай “Хөшөөт” формацын тунамал зузаалаг чулуулгийн ан цавын усжсан бүсийн алаг цоог тархалттай

газрын доорх ус нь зонхилон чөлөөт гадаргуутай байх боловч гүнийн хэсэгт түрэлтэт төлөв байдалтай мөн тааралдана. Бүс нутгийн геологийн тогтоц, давхарга зүйн онцлог, янз бүрийн найрлагатай чулуулагт агуулагдах газрын доорх усны тархалт, эргэлтийн онцлог зэргээс хамааруулан судалгааны талбайн хэмжээнд гидрогеологийн давхарга зүйн ангиллыг дараах байдлаар авч үздэг. Үүнд:

- ✚ Голоцен-плейстоцены настай сэвсгэр хурдасны зузаалаг дахь уст давхарга (QII-IV)
- ✚ Дээд пермийн настай “Хөшөөт” формацын вулканоген-тунамал зузаалаг дахь ан цавын усжсан бүсийн алаг цоог тархалттай газрын доорх ус

2.4 Хөрсний хэв шинж

Тус талбай нь Монгол орны уулархаг бүс, Монгол Алтайн нурууны экосистемд байрлана. Тус талбайн зүүн талаар Сутай уул, баруун талаар Баатар хайрханы нуруу байрлана. Гадаргын өндөршлийн хувьд далайн түвшнээс дээш 1984-2216 метр орчимд хэлбэлзэх бөгөөд Салхит уул, Дэтгийн даваа, Баян-Өндөр, Авдрант зэрэг өндөрлөг газрууд байна. Тус талбай нь Монгол орны Физик-Газарзүйн мужлалтаар Алтайн уулархаг их мужийн Монгол Алтайн мужийн Монгол Алтайн зүүн тойрогт багтана. Харин Хөрс-Газарзүйн мужлалтаар Говийн их мужийн Өндрийн бүшилтэй нутгийн Монгол Алтайн мужийн Алтайн чанадахь 53-р тойрогт багтаж байна.

Шинжилгээний дүнгээс харахад ялзмагийн агууламж бүх дээжинд бага хэмжээнд байна. Урвалын орчин 1-р зүсэлтийн А үед дунд шүлтлэг, В үед маш хүчтэй шүлтлэг орчинтой. 2-р зүсэлтийн А үед хүчтэй шүлтлэг, В үед маш хүчтэй шүлтлэг орчинтой болсон. 2 зүсэлт гүн рүүгээ шүлтлэг орчин огцом нэмэгдэж байна.

Хөрсний цахилгаан дамжуулах чадавхийн хувьд 1-р зүсэлтийн А, В үе, 2-р зүсэлтийн А үед давсжилтгүй, харин В үед сул давсархаг шинжтэй байна. Хөрсний карбонатын агууламж 2 цэгийн өнгөний дээжинд илрээгүй бол 1 болон 2-р зүсэлтийн В үед дунд зэрэг карбонатжсан. Хөрсний үржил шимийн үзүүлэлтийн хувьд 1-р зүсэлтийн А үед хөдөлгөөнт суурийн нийлбэр 24.5 мг/100г, фосфор дунд, калий дундаж. В үед 23.6 мг/100г, фосфор дундаж, калий дундаж байна. 2-р зүсэлтийн А үед 39.9 мг/100г, фосфор маш бага, калий дунджаас дээгүүр, В үед 22.6 мг/100г, фосфор дундаж, калий дундаж байна. Бүх дээжинд калийн ион илт давамгайлсан шинжтэй.

Судалгааны талбайд тархсан хөрсний механик бүрэлдэхүүн элс, шавар, тоосны харьцаа 1-р зүсэлтийн А үед 51:28:21, В үед 27:28:45 байна. 1-р зүсэлтийн элсний агууламж 27-51%,

тоосны агууламж 28%, нарийн ширхэгт шаврын агууламж 21-45% байна. Качинскийн ангиллаар тус хөрсний А үе элсэрхэг шавранцар, В үе шаварлаг механик бүрэлдэхүүнтэй хөрс байна. 2-р зүсэлтийн элс, шавар, тоосны харьцаа А үед 50:30:20, В үед 25:36:39 байна. Элсэн фракци 25-50%, тоосны фракци 30-36%, наанги шаврын агууламж 20-39% байна. Качинскийн ангиллаар тус хөрсний А үе элсэнцэр, В үе хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй хөрс байна.

2.5 Ургамлан нөмрөгийн онцлог

Хөшөөтийн нүүрсний орд орчмын талбай нь Монгол Алтайн нурууны уулсын системийн Дорнод Алтайн Сутайн баруун хойт салбар Баатар Хайрхан–Сутайн районд хамаарна (Beket, 2009).

Ургамалжлын зүйлийн бүрэлдэхүүн: Судалгааны талбайн нь бэлчээр бөгөөд 4 бүлгэмдэлд 14 овгийн 33 төрлийн нийт 39 зүйл ургамал бүртгэгдсэн. Энэхүү ургамал нь амьдралын хэлбэрийн хувьд Сөөг-2, Сөөгөнцөрлөг-1, хагас сөөгөнцөрлөг-2, Олон наст өвс-30, Ганц ба хоёр наст-4 зүйл ургамал тус тус тэмдэглэгдэв.

Ургамалжлын 1-р цэг: Судалгааны нэгдүгээр цэгт 5 овгийн 8 төрлийн 9 зүйл ургамал бүтгэгдсэн. Арвийн үнэлгээний хувьд зонхилогч зүйл ургамлууд нь сор1, бусад зүйл ургамлууд нь sp-sol үнэлгээтэй. Нийт 56%-ийн тусгаг бүрхэцтэй, үүнээс сөөгөнцөр ургамал-1%, биелэгтэн ургамлынх 36%, олон наст өвслөг ургамал-22%-ийг тус тус бүрдүүлж байна. Ургамлын дундаж өндөр-14 см. Зун эртийн зүйл болох имт Гичгэнэ, шүдэнцагаан Хунчир гэсэн 2 зүйл ургамал цэцэглэсэн. Ургамалжлын аспект ногоон.

Ургамалжлын 2-р цэг: Судалгааны нэгдүгээр цэгт 4 овгийн 6 төрлийн 7 зүйл ургамал бүтгэгдсэн. Арвийн үнэлгээний хувьд зонхилогч зүйл ургамлууд нь сор1, бусад зүйл ургамлууд нь sp-sol үнэлгээтэй. Нийт 42%-ийн тусгаг бүрхэцтэй, үүнээс биелэгтэн ургамлынх 28%, олон наст өвслөг ургамал-18%-ийг тус тус бүрдүүлж байна. Ургамлын дундаж өндөр-12 см. Ургамалжлын аспект ногоон. Энэхүү бүлгэмдлийн өнөөгийн төлөв байдал хүчтэй доройтолд орсны улмаас уг бүлгэмдэл флорын баялагаараа ядмаг болсон байна. Тухайн бэлчээрт доройтлыг илэрхийлэгч ургамлууд зонхилсон байна.

2.6 Амьтны аймгийн зүйлийн бүрдэл, тоо толгой, тархалт

Төсөл хэрэгжих талбай болон талбайн ойр орчим өндөр уулын хээрийн бүслүүрийн амьтад зонхилно. Сэнж, Ханан ба Баатархайрханы нурууны зүүн хэсэг болон түүний ойр орчмын нутагт нийт 13 багт хамаарах 41 овгийн 108 зүйл амьтад байгаагаас хөхтөн амьтдын

5 багт хамаарах 14 овгийн 47 зүйл, шувуудын 6 багийн 23 овгийн 56 зүйл, мөлхөгчдийн 2 багийн 4 овгийн 5 зүйл амьтан байна. Энд өндөр уул нуруудын өвөр хэсгээр Төв Азийн говь, цөл, цөлөрхөг хээр, харин уулсын арын өргөн бэл, тал хөндий, ухаа гүвээрхэг хотос хоолойгоор хээр, цөлөрхөг хээрийн бүс зонхилох тул хээрийн төдийгүй говь, цөлийн амьтад ч оршин амьдардаг онцлогтой юм.

Шувуу: Төслийн талбай болон төслийн талбайн ойр орчимд шувууны ангиас шонхортон (Falconiformes), тогоруутан (Gruiformes), тахиатан (Galliformes), тагтаатан (Columbiformes), өвөөлжтөн (Upuriformes), боршувуутан (Passeriformes) зэрэг 6 багт хамаарах 2 овгийн 56 зүйл шувуу тархжээ.

Хоёр нутагтан ба мөлхөгчид: Хоёр нутагтан, мөлхөгчид бол бусад сээр нуруутан амьтадтай харьцуулахад илүү эмзэг бүлэг бөгөөд эх газрын эрс тэс уур амьсгалтай монгол нутагт орших хоёрнутагтан, мөлхөгчдийн зүйлийн олон янз байдал дэвсгэр газрын хэмжээтэй харьцуулахад дэндүү хомс юм. Төслийн талбай орчимд цоохор хонин гүрвэл, могой гүрвэл, говийн гүрвэл, рашааны могой, бамбай хоншоорт могой зэрэг мөлхөгчид тархдаг.

Ховор амьтад: Монгол улсын Улаан номонд орсон янгир (*Capra sibirica*), аргал хонь (*Ovis ammon*), цоохор ирвэс (*Uncia uncia*), мануул мий (*Otocolobus manul*), шилүүс (*Lynx lynx*), эрээн хүрэн (*Vormela peregusna*), таван хуруут атигдаахай (*Cardiocranium paradoxus*), алтайн хойлог (*Tetraoedus altaicus*) зэрэг 8 зүйл, Монгол улсын Ан агнуурын тухай хуулийн Хавсралтын Нэн ховор, Ховор амьтны жагсаалтад орсон янгир (*Capra sibirica*), аргал хонь (*Ovis ammon*), шар үнэг (*Vulpes vulpes*), саарал чоно (*Canis lupus*), цоохор ирвэс (*Uncia uncia*), мануул мий (*Otocolobus manul*), шилүүс (*Lynx lynx*), эрээн хүрэн (*Vormela peregusna*), алтайн хойлог (*Tetraoedus altaicus*) 9 зүйл, Монгол орны Улаан дансны эмзэг зэрэглэлд орсон 4 зүйл, устаж болзошгүй зэрэглэлд 3 зүйл, ховордож болзошгүй зэрэглэлд 7 зүйл байна.

3. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ

Нөлөөлөлд өртөөгүй, байгалийн унаган төрхөөрөө байгаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн Байгаль орчны төлөв байдлын судалгааны үе шатанд орчны агаар, ус, хөрс, ургамал, газрын гадаргын бохирдол, доройтлын түвшинг тодорхойлж, хөрснөөс дээж авч лабораторийн шинжилгээ хийлгэн үнэлгээ дүгнэлт өгсөн.

Төслийн голлох нөлөөллийг тодруулахад доорх 3 зүйлийг анхаарах шаардлагатай болдог. Үүнд:

- ✚ Үйл ажиллагааны бохирдлын түвшинг тодорхойлж, харгалзан үзэх
- ✚ Нөлөөллийг үр дагаврыг бууруулах арга замыг тодруулах
- ✚ Төслийн альтернатив хувилбаруудыг тодорхойлж өгөх явдал юм.

Төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээнээс улбаалан байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөллийг тодорхойлбол:

- ✚ Хөрсний эвдрэл, элэгдэл
- ✚ Ургамлан нөмрөг устгах
- ✚ Нүүрс ачиж буулгах үед үүсэх тоосжилт

Голлох нөлөөллийн хамрах хүрээ, эрчмийг нэгтгэж доор хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3. Төсөл хэрэгжих үеийн голлох нөлөөллийн хамрах хүрээ, түүний эрчим

№	Төслийн гол нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа
1	Нүүрсний овоолго, зам, барилгын сууриар хөрсөн бүрхэвч устгах	Хөрс, ургамал	Дунд зэрэг	Төслийн эхэнд
2	Ургамлан нөмрөг устгах	Ургамал бүрхэвч	Дунд зэрэг	Төслийн эхэнд
3	Агаарын бохирдол, тоосжилт	Агаар, ажилчид, ургамлан нөмрөг	Дунд зэрэг	Төсөл хэрэгжих хугацаанд

3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Ачилт буулгалтын талбайн үйл ажиллагааны үед орчны агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, бууруулахын тулд доорх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлбэл зохино. Үүнд:

- Тоосжилт бууруулах 8 м-ээс багагүй өндөртэй зориулалтын хашааг талбайн хойд болон баруун талыг тойруулан барьснаар хашаа нь 70 кг/см² байх салхины хүчийг сааруулах бөгөөд ингэснээр салхийг чиглэлийн дагуу задлан сааруулж хурдыг эрс багасаж, нүүрсний овоолгоос гарах тоосны хэмжээ буурна.

- Нүүрс ачиж буулгах, тээвэрлэх, овоолго хийх явцад тоосжилтыг бууруулахын тулд зохиомол мананжуулагч төхөөрөмжийг ашиглах;
- Тээвэрлэлтийн машин механизм, тээврийн хэрэгслүүдээс агаарыг бохирдуулагч их хэмжээний бодис ялгардаг. Үүнд хяналт тавьж тухайн техникийн хорт хий ялгаруулалтыг ЗДА-ын хэмжээнд нь барьж /боломжтой бол шүүлтүүр тавьж/ ажиллах;
- Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор амны хаалт зэрэг хамгаалах хэрэгслийг хэрэглүүлж хэвшүүлэх;

3.2. Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Төслийн үйл ажиллагааны үед газрын доорх усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж доорхи арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино. Үүнд:

- Төслийн тээвэрлэлтийн явцад орчны тоосжилтыг бууруулахад газар доорх усны нөөцийг ашиглахаас аль болох зайлсхийж, цэвэршүүлсэн ахуйн хаягдал усыг эргүүлж ашиглах боломжийг судлах, боломжтой бол ашиглах;
- Усыг ариг гамтай, зүй зохистой ашиглаж, усны хэрэглээг хамгийн бага түвшинд байлгах;
- Усны хэрэглээний талаар ажилчид болон иргэдэд зөвлөмж сурталчилгааны самбарыг байрлуулах, сургалт зохион байгуулах;
- Ус ашиглах гэрээний дагуу ус ашигласны төлбөрийг цаг тухайд нь төлөх, гэрээнд хүлээсэн үүргийг биелүүлэх, хугацааг мөрдөх;
- Барилга байшингийн дээврээс борооны усыг тосож цуглуулах, цуглуулсан усаар ногоон байгууламжийг услах;
- Замыг төлөвлөхдөө борооны усыг ногоон байгууламжийн талбай руу урсахаар тооцон төлөвлөх;

3.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зорилгоор төсөл хэрэгжүүлэгч доорхи арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнд:

- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-д заасан эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж, мод тариалах шаардлагын дагуу зүлэгжүүлж, моджуулах арга хэмжээг зайлшгүй хийх;
- Автомашины зам, зогсоолыг хатуу хучилттай болгох;
- Хатуу, шингэн хог хаягдлаар хөрсөн бүрхэвчийг бохирдуулахаас урьдчилан

сэргийлж хог хаягдлыг богино хугацаанд зайлуулах, ахуйн хаягдлыг ангилан ялгаж дахин боловсруулах боломжтой цаас хуванцар зэрэг хаягдлыг дахиврын үйлдвэрт тушаах арга хэмжээ авах;

- Ахуйн хатуу хог хаягдлын цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн байгуулах;
- Техникийн шатах тослох материал асгарч гоожвол нэн даруй элс, даавуу зэрэгт шингээн галын аюулгүй нөхцөлд ариутгах, эсвэл дарж булах байдлаар цэвэрлэх;
- Машин техникийн засвар үйлчилгээний үед гарах сэлбэг хэрэгсэл болон дугуйн хаягдлыг хаягдал дугуй боловсруулах үйлдвэрүүдтэй гэрээлсэний үндсэн дээр тогтмол зайлуулж байх;

3.4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор доорхи арга хэмжээнүүдийг хэрэгжүүлбэл зохино. Үүнд:

- Төслийн эргэн тойрны талбайн ургамлын биомассын хэмжээ төслийн үйл ажиллагаанаас хамаарч буурах магадлалтай тул ургамалжуулах;
- Тоосжилтоос үүдэн ургамлын амьдрах чадвар буурч, фотосинтезийн үйл ажиллагаа явагдахгүй болох магадлалтай тул тоосжилт үүсэх эх үүсвэрүүдийг услах, тоосжилт үүсэх арга замуудыг багасгах;
- Хог хаягдлыг ангилан ялгах, хадгалах, тээвэрлэх бүхий л үйл ажиллагаанд холбогдох хууль, журам, стандартыг баримтлах;
- Авто тээврийн хөдөлгөөн, төсөл хэрэгжиж буй талбайгаас гадна орших ургамлыг талхагдалд оруулахгүй байх бүхий л арга хэмжээг авах, шаардлагатай объектуудад хашаа барих, ургамлан нөмрөг доройтоогүй газраар машин техник нэвтрүүлэхгүй байх;
- Боломжит газруудад ногоон байгууламжийг зохих арга технологийн дагуу байгуулах, тохижуулах;
- Төслийн барилга байгууламж барьсан талбайн хэмжээтэй тэнцэхүйц хэмжээний өөр газарт ургамлан бүрхэвчийг нөхөн сэргээх, гадаад орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэх;
- Нөхөн сэргээлтэд тухайн бүс нутгийн унаган ургамал, мод бутыг ашиглах, ургах чадвар сайтай, нөхөн сэргээлтэд ашиглахад ирээдүйтэй нутгийн ургамлуудыг сонгон шалгаруулан тарих, үрийн нөөц бэлтгэх;
- Ургамлын нөхөн сэргээлтийг тухайн газрын онцлогтой уялдуулан гүйцэтгэх зорилгын үүднээс энэ ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар гүйцэтгэх;

- Ургамлан нөмрөгийн өсөлт, хөгжилт, өөрчлөлтөд тодорхой давтамжтайгаар мониторинг буюу судалгааг хийх;

3.5. Ажилчдын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

- Ажилчид ба багийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй хүлээн авч зохих хэмжээнд нь шийдвэрлэж заавал хариу өгөх;
- Бүх ажилчдад ажил үүргийн хуваарьтай нь уялдуулан ХХАА-ны зааварчилгааг тогтмол өгч сургалт зохион байгуулах, ажилчдын аюулгүй ажиллагааг хангах;
- Ашиглаж буй техник, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд завсар үйлчилгээг хийх, аюулгүй ажиллагааг хангах;
- Бүх ажилчдад аливаа болзошгүй аваар ослын үед анхны тусламж үзүүлэх сургалт зааварчилгааг өгөх;
- Анхны тусламжийн эм тариа, багаж хэрэгслийг бэлэн байлгах;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжилт үр дүнд хяналт тавих;
- Аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол, ойлгомжтой хэлбэрээр өгөх, ойлголтыг баталгаажуулах;
- Аюул, эрсдэл, хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлсийн талаар бодит мэдээллээр хангах, аюулгүй ажиллах зан үйлд сургах, ажлын дадлага хийлгэх;
- ХАБЭА-н талаар зохион байгуулсан, хэмжсэн, үнэлсэн, аюул, эрсдэлийг арилгасан арга хэмжээ бүрийг нийт ажиллагсдад мэдээлж байх;

3.6. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ

- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлангийн “Үйл ажиллагааны хүрээ”-нд тусгагдсан төслийн үйл ажиллагаатай холбоотой хуулиудын заалтууд, байгаль орчныг хамгаалах болон бусад стандарт, норм, дүрмийг төслийн үйл ажиллагааны бүхий л хугацаанд мөрдөж ажиллах;
- Төслийг аль болох сөрөг нөлөө багатайгаар хэрэгжүүлэхийн тулд гүйцэтгэсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн бүлгүүд дэх судалгаа, үнэлгээний үр дүн болон зөвлөмж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэргийг тулгуур хэрэглэгдэхүүн болгон ашиглаж, байгаль хамгаалах жил бүрийн ажлыг нарийвчлан тогтоож хэрэгжүүлэх;

- Нийт ажиллагсдад байгаль хамгаалах талаар хууль тогтоомжийг танилцуулан энэ талын мэдлэг эзэмшүүлэх, ажлын байранд хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч байх;
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, орон нутгаас зөвшөөрөгдсөн талбайд хог хаягдлыг хаях, хуулийн дагуу хаягдлыг тээвэрлэх, устгах;
- Байгаль орчныг хамгаалахад чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж байх;

4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай багц хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” 2025 онд “Турван орчил мандал” ХХК-ийн боловсруулсан, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлангаар тодорхойлогдсон байгаль орчинд ямар сөрөг нөлөөлөл үзүүлж байгааг тодорхойлсны үндсэн дээр тус төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор хүрээлэн буй орчинд, хүний эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөлөл, түүнээс сэргийлэх арга зам, анхаарвал зохих асуудлын талаар нарийвчлан тусгаж, 2026 оны Гаалийн хяналтын бүсийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа. Үүнд:

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр заавал авч хэрэгжүүлж байх арга хэмжээ, агаар, хөрс, ус зэрэг байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд хяналт шинжилгээний хөтөлбөрт тодорхой тусгаж оруулсан болно.

4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Энэ хэсэгт байгаль орчны судалгааны явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зардал зэргийг оруулсан болно.

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар									
1	Нүүрс тээвэрлэх, ачих, буулгах зэрэг төслийн талбай дээр хийгдэх ажлын үед тоосжилт үүсэх	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор дулааны улиралд тогтмол усалгаа хийх;	Гаалийн талбай	тн/км	0.19	10000	1,880.0	Тогтмол	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2		Талбай орчмын авто машины хяналт тавьж, хурдны хязгаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээ байршуулах	Нүүрс ачиж, буулгах талбай	км	1,000.0	1	1,000.0	Улиралд нэг удаа	
3	Тээврийн хэрэгслийн хөдөлгүүр хорт хий ялгаралт	Тээврийн хэрэгслийг жил бүр үзлэгт хамруулж, агаарын бохирдлын төлбөрийг төлөх, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх;	4 дугуйт ачигч, 1 усны машин, 1 хогны машин, 1 түлш цэнэглэгч, 1 суудлын машин	ш	200.00	5	1,000.00	1 удаа	“Бензин хөдөлгүүртэй автомашин– утааны найрлага дах хорт бодисын ЗДХ ба хэмжих арга” MNS 5013:2009 “Дизель хөдөлгүүртэй автомашин– утааны тортогжилтын ЗДХ ба хэмжих арга” MNS 5014:2009
4	Ахуйн хог агаар бохирдох	Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хаягдлын цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн	Хаягдлын цэгийн орчимд	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу			14 хоног тутамд	Хог хаягдлын тухай хууль, 2017 он	

		битүүмжлэл сайтай хийх, хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах								
Газрын гадарга, хөрсөн бүрхэвч										
5	Хог хаягдлаар газрын гадарга, хөрсөн бүрхэвч бохирдох	Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хаягдлыг үүсэх шатанд нь ангилан ялгах зориулалтын хог сав байршуулах,	Гаалийн талбай	ш	200	2	400	1 удаа	Хог хаягдлын тухай хууль, 2017 он	
6		Боловсруулах боломжгүй хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасаны дагуу				14 хоног тутамд	Хог хаягдлын тухай хууль, 2017 он	
7		Холбогдох журмын дагуу бохирын танк суурилуулна.		тн	3000	1	3,000.00	1 удаа	Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам.	
Газрын доорхи ус										
8	Газрын доорх усны нөөцөд сөргөөр нөлөөлөх	Усны газраар ус ашиглах дүгнэлт гаргуулж “Ус ашиглах гэрээ” байгуулан усны төлбөр тооцоог цаг хугацаанд нь төлөх	Зүүн хөшөөтийн төслийн үйл ажиллагааны зардалд багтаасан				Усны тухай хууль			
Нийт мян.төг			7,280.00							

4.2 Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөө

Хүснэгт 5. Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал мян. Төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн бичиг баримт
	1	2	3	4	5	6	7	8
1	Тэрбум мод хөтөлбөр болон биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө Зүүн хөшөөтийн нүүрсний уурхайн төслийн 2026 оны БОМТ-д тусгагдсан.		*	3000		Төслийн БОМТ-д тусгагдсаны дагуу		MNS 6140:2010 Техникийн шаардлага, MNS 6254:2011 Мод, сөөгний суулгацыг бойжуулах. Ерөнхий шаардлага;
2	Нийт					0.0		

4.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

“Гаалийн хяналтын талбай байгуулах” төслийн үйл ажиллагаанд өртөх газар нь газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртөн нөхөн сэргэхгүй үлдэх газарт хамаарахгүй тул биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг гүйцэтгэх шаардлагатай төсөлд үл хамаарна.

4.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаагаар газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажил явагдахгүй.

4.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Талбайн орчимд түүх соёлын дурсгалт зүйлс байхгүй бөгөөд төслийн үйл ажиллагааны үед түүх соёлын дурсгалт зүйлсийг хөндөх, түүнд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй тул БОМТ-нд түүх соёлыг хамгаалах арга хэмжээ тусгагдаагүй болно. Харин төслийн үйл ажиллагааны

үед түүх соёлын дурсгалт зүйлс, булш, бунхан хиригсүүр, археологи, палентлогийн зүйлс илрэх тохиолдолд соёлыг өвийг хамгаалах үүднээс үйл ажиллагааг зогсоож, хууль ёсны дагуу мэргэжлийн байгууллагад хандаж мэдэгдэл хүргүүлнэ.

4.6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	7	8	9	
1		Бүх төрлийн ахуйн хатуу хог хаягдлыг үүсгэх шатанд нь ангилан ялгах төрөлжүүлсэн савнууд байршуулах	Барилга байгууламж	Ширхэг	100	500	1 удаа	Хог хаягдлын тухай хууль
2	Орчны бохирдол	Ахуйн хатуу хог хаягдлын түр хадгалах цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн битүүмжлэл сайтай, галд тэсвэртэй материалаар хийнэ	Гаалийн хяналтын бүсийн талбайд	Ширхэг	500	500	2 удаа	Ахуйн хаягдал тээвэрлэхэд тавигдах ерөнхий шаардлага
3		Ангилж ялгасан дахин боловсруулах боломжтой ахуйн хатуу хог хаягдлыг дахиварын үйлдвэрт тушаах, боловсруулах боломжгүй хэсгүүдийг зөвшөөрөгдсөн төвлөрсөн хогийн цэгт зайлуулах	Хог хаягдлын цэгийн хүрээнд	тн	150.00	1800	сард 1 удаа	
4	Шингэн хаягдлаар хөрс, газрын доорх ус бохирдох	Шингэн хаягдал тээвэрлэн зайлуулах гэрээт байгууллагатай гэрээ байгуулах	*	тн	Үйл ажиллагааны зардал		Тухай бүрт	Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж

							тохижуулах журам.
5	Шатахуун, тос тосолгооны материалын хаягдлаар хөрс, газрын доорхи ус бохирдох	Техникийн шатах тослох материал асгарч гоожвол нэн даруй элс, даавуу зэрэгт шингээн галын аюулгүй нөхцөлд ариутгах, эсвэл дарж булах байдлаар цэвэрлэх, саармагжуулах	Гаалийн хяналтын талбай	тн	Асгарсан тохиолдолд нэг даруй		Хөрс. Эрүүл ахуйн үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ MNS 3297:1991
6	Машин техникийн засвар үйлчилгээний үед гарах сэлбэг хэрэгсэл болон дугуйн хаягдлыг хаягдал дугуй боловсруулах үйлдвэрүүдтэй гэрээлсэний үндсэн дээр тогтмол зайлуулж байх			тн	Сэлбэг хэрэгсэл, дугуй, тос тосолгооны материалын хаягдал гарсан тохиолдолд зайлуулах зардлыг үйл ажиллагааны зардалд оруулан төлөвлөх	сард 1 удаа	ÿ Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008.
Нийт мян.төг				2,800.0			

4.7 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 7.Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн бичиг баримт
1	2	3	4	5	6	7	8	
1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	Ажиллагсдыг ХХАА-ны хувцас хэрэгсэл буюу бээлий, маск, хошуувч, хамгаалах хэрэгслээр бүрэн хангах, хэрэглүүлж хэвшүүлэх	Төслийн бүх ажилчид		Төслийн үйл ажиллагааны зардал		Тухай бүрт	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль; Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй MNS 4990:2000, Хөдөлмөр хамгаалал стандартын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага MNS 4244:94, Хөдөлмөр хамгаалал стандартын систем, Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага MNS 4244:94
2		Төслийн бүх ажилчдад өдөр бүр ажил эхлэхээс өмнө ХХАА-ны зааварчилгаа өгч гарын үсэг зуруулах, ХХАА-ны зааварчилгаанд хамрагдаагүй ажилчдыг тухайн өдөрт ажиллахыг хориглох		*	*	Тогтмол		
3		Ажилчдад анхны тусламж үзүүлэх арга зааврыг эзэмшүүлэх, Анхан шатны тусламжийн эм, тариа, багажийг хяналтын өрөө эсвэл ажлын байруудын аль тохиромжтой газар байрлуулах	Төслийн бүх ажилчид	4	250.0	1,000.0	Улирал тутам	
4	Галын аюулгүй байдал	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалын	Барилга байгууламж	4	300.0	1,200.0	Улирал тутам	

		заасан самбар галын аюул болж болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг					
5	Гамшгаас хамгаалах	Үерийн эрсдэл бүхий цэгүүдэд ус зайлуулах суваг шуудуу татах	Шаардлагатай газруудад	Үйл ажиллагааны зардалд багтааж тусгасан			1 удаа
6	Нийт мян.төг						2,200.0

4.8 Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 8. Удирдлаг, зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв /мян. төг/	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 он				
			Сар 4	Сар 8	Сар 11		
1	2	3	4	5	6	7	
1	Нүүрс тээврийн гэрээт компаниудтай хамтран ажиллах гэрээнд байгаль хамгаалах үүрэг хариуцлагыг тухай тусгах	*	*	*	*	Байгаль орчны мэргэжилтэн;	Гэрээний дагуу байгаль орчинг хамгаалах шаардлагыг биелүүлж буй эсэхэд хяналт тавин ажиллах;
2	Байгаль орчны чиглэлийн сургалтын үйл ажиллагааг шат дараалалтай тогтмол явуулах	200	*	*	*	Байгаль орчны мэргэжилтэн;	Нийт ажилчдад
3	Нийт мян.төг					200	

4.9 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах

Хүснэгт 9. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян. төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Дарви сумын байгаль орчны байцаагч болон байгаль хамгаалагчид шаардлагатай мэдээ тайланг хүргүүлэх; /ус ашиглалт, хог хаягдал/	Тайлан	Мэдээ тайлангууд;	Улиралд 1 удаа;	*	Байгаль орчны мэргэжилтэн;	*
2	Сум орон нутгийн багийн хуралд танилцуулга тавих;	Танилцуулга	Үйл ажиллагааны тухай;	Товлогдсон хугацаанд;	*	Байгаль орчны мэргэжилтэн ;	*
3	Иргэдийн төлөөлөл, шалгалтын комисс;	Танилцуулга	Биелэлтийн тайлан;	12 сар;	300	Байгаль орчны мэргэжилтэн ;	*
4	Нийт				300.00		

Хүснэгт 10. 2026 оны гаалийн хяналтын бүсийн БОМТ-ний нийт зардал

Д.д	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	7,280.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний зардал	2,500.0
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	*
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний зардал	*
5	Түүх соёлын өвийг хамгаалах	*
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал	2,200.0
7	Хог хаягдлын менежментийн зардал	2,660.0
8	Удирдлага төлөвлөгөөний зохион байгуулалтын зардал	11,000.0
9	Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөний зардал	1,300.0
10	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний зардал	300.0
11	Нийт зардал	27,240.00